



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

Хяналтын хорооны бүрэлдэхүүн
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.1, 77.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Улс, нийслэлийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлын явц гүйцэтгэл, өмчийн бүртгэл, эзэмшил, ашиглалтад хяналт тавих чиг үүрэг бүхий Хяналтын хороог шинэчлэн дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хяналтын хорооны дарга	М.Давааням	Хурлын нарийн бичгийн дарга
Гишүүд	Б.Гэрэлмаа	бөгөөд Ажлын албаны дарга
	М.Энхболд	Төлөөлөгч
	Д.Цэвэгдорж	Төлөөлөгч
	Д.Баттөр	Төлөөлөгч
	Д.Ууганбаатар	Төлөөлөгч
	Б.Бат-Эрдэнэ	Төлөөлөгч
	С.Ханддорж	Төлөөлөгч
Нарийн бичгийн дарга	Б.Арвижих	Эрх зүй, тогтоол шийдвэрийн биелэлт, орон нутгийн өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Төсвийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу улс, нийслэл, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг танилцуулж ажиллахыг Хяналтын хороо (М.Давааням)-нд үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Зөвлөлд даалгасугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан 2023 оны 06 сарын 29-ний өдрийн “Хяналтын хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/21 дүгээр тогтоолыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ

E:\2024 он\Хэвлэмэл хуудас\Тогтоол А.docx

1123100087